



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№95 /308/

2022.05.18

Цаг үе, үйл явдал

ДӨЛ ТЭМЦЭЭНИЙ ШИЛДГҮҮД ШАЛГАРСААР БАЙНА



Орхон аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Орхон аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг энэ сарын 14, 15-нд Эрдэнэт спорт амралтын хүрээлэнгийн байрлалд амжилттай зохион байгууллаа.

Тус тэмцээн нь Орхон аймгийн

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгох, эх орон, эх хэл, түүх соёл, уламжлал, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдар сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил олгож, эх орноо Батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх, Монгол цэргийн залгамж халааг

бэлтгэх зорилготой юм

Тэмцээнд 2 сумын 16 тасгийн 208 сурагчид хурд, хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт Н.Нямдаваа тасгийн захирагчтай Орхон аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын V сургууль, дэд байрт Э.Эрдэнэжаргал тасгийн

захирагчтай Ерөнхий боловсролын XIV сургууль, гутгаар байрт Д.Пүрэвдорж тасгийн захирагчтай ерөнхий боловсролын XVIII сургууль, тусгай байрт Э.Хосбаяр тасгийн захирагчтай XVII сургууль, Д.Доржзодов тасгийн захирагчтай I сургууль тус тус шалгарч медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал хүртлээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
20	3

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	27

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,125.00	3,133.0
EUR	3,270.0	3,300.0
CNY	460.00	463.00
RUB	41.60	42.00
JPY	24.10	24.80
KRW	2.42	2.46

ЗУРХАЙ



ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭГТЭЙ ЦАГААН МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.11-20.26

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

Төрөн түгэхүй

Суудал: Мод

Энэ өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмтнийг шийтгэх, угаал үйлдэх, тангараг тавих, гэр бүрэхэд сайн. Хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойшоо мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ОЛОН УЛСЫН СУВИЛАГЧ НАРЫН БАЯРЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



БНӨСҮ

Олон улсын сувилагч нарын баярыг тохиолдуулан батальоны сувилагч нар энэхүү тэмдэглэлт өдрийг албан ёсоор энэ сарын 12-ны өдөр Бентью хот "Хувилай" баазад зохион байгуулан явууллаа. Арга хэмжээг нээж Мотобуудлагын батальоны захирагч журандаа О.Заяат хэлэхдээ "Бид бүхний эрүүл мэндийг хариуцан ажиллагааны өмнөх бэлтгэлээс өнөөдрийг хүртэл халуунд халж, хүйтэнд хөрж, өдөр шөнөгүй өргөсөн тангарагтаа үнэнчээр шантралгүй үүргээ амжилттай гүйцэтгэж байгааг хэлэхэд таатай байна. Цар тахлын хүнд хэцүү цагт өөрийн эрүүл мэндийг үл хайрлан үнэнчээр хөдөлмөрлөсөн та бүгдэд энэ хорвоогийн хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж Олон улсын сувилагч нарын баярын мэндийг хүргэе" гэв. Түүнчлэн олон Улсын сувилагч нарын баярыг тохиолдуулан сувилагч нар тангараг өргөх ёслолын арга хэмжээг 11.40 цагт соёлын төвд



батальоны удирдлага болон ротын захирагч, эмч, сувилагч нарын хамт зохион байгуулж явууллаа. Мотобуудлагын батальонд үүрэг гүйцэтгэж байгаа хосолсон тангарагтай сувилагч нар бие бүрэлдэхүүнд хүндэтгэл үзүүлэн олон улсын сувилагч нарын баярын талаарх танилцуулга хийж, зурх, уушгины дасгалыг заав. Мөн эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга хошууч М.Хишигбаяр өөрсдийн дотоод боломжоор урласан хүүхдийн хувцсыг хүлээлгэн өгч, батальоны удирдлага болон ротын захирагч нарт сувилагчийн эрхлэн гаргасан бяцхан зөвлөмжийн номыг гардуулж өглөө. Мөн "Сувилагчийн түүхэн замнал" сэдвээр ахлах сувилагч ахлах ахлагч Б.Солонгоо илтгэл тавьж, сувилагч нар тангаргаа өргөн Монгол Улсын төрийн далбаанд хүндэтгэл үзүүлээ. Мөн эмч сувилагч нарт мэндчилгээ хүргэж ахлах дэслэгч Ц.Бадамсүрэн дэд ахлагч Б.Батболд нар сувилагчийн

бүжиг, дотрын эмч ахлах дэслэгч С.Чанцалсүрэн, Х.Гарьд, дэд ахлагч Б.Батзаяа нар ая дууны мэндчилгээ дэвшүүлээ. Эмч нарын зүгээс

сувилагч нартаа зориулж ар гэрийн мэндчилгээ, үйл ажиллагааг харуулсан дүрс бичлэгийг үзүүлэн гэнэтийн билэг бариллаа.

ПАРИАН СУУРИНЫ БИЕ БҮРЭЛДЭХҮҮН СПОРТ, УРЛАГИЙН ТОГЛОЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Париан сууринд үүрэг гүйцэтгэж буй хошууч Ц.Баатарсүрэн захирагчтай 2МБР-ын авьяаслаг залуучууд "Хувилай" баазад урлагийн тоглолтыг зохион байгууллаа.

Урлагийн тоглолт дөрвөн хэсгээс бүрдсэн ба эх орон, эрчүүд, эмэгтэйчүүд, энхийг сахиулагч нарт зориулсан сэдэв агуулгаар бэлтгэсэн тоглолт байлаа.

Мөн хошууч Ц.Баатарсүрэн Зэвсэгт хүчний 123 дугаар ангийг сурталчлах арга хэмжээний хүрээнд гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа.

Гар бөмбөгийн тэмцээний нэгдүгээр байранд 1МБР-ын ахлагч Б.Жамсранжав ахлагчтай баг, хоёрдугаар байранд 2МБР-ын дэд

ахлагч Н.Отгонбаатар ахлагчтай баг, гуравдугаар байранд ХТР-ын дэслэгч Э.Энхтөр ахлагчтай багууд тус тус шалгарлаа.

Ахлах дэслэгч Ц.БАДАМСҮРЭН



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 523,209,618

Эдгэрсэн

Нийт: 493,085,893

Нас барсан

Нийт: 6,290,453

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БАТЛАГДСАН

8505

+112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

12

ЭДГЭРСЭН

8372

АТХАЛТ ХҮНИЙ БИЕ МАХБОДИД ХЭРХЭН НӨЛӨӨЛДӨГ ВЭ?

- 3 МИНУТ ЦУСНЫ ДАРАЛТ ВУРДАГ
- 5 МИНУТ СЭТГЭЛ САНАА ӨӨДРӨГ БОЛДОГ
- 5-10 МИНУТ ВҮТЭЭГЧ СЭТГЭЛГЭЭ СЭРГЭДЭГ
- 15 МИНУТ ЦУСАН ДАХЬ САХАРЫН ХАМЖЭЭ ВУРДАГ
- 30 МИНУТ ЖИН ХАСААД ТУСАЛДАГ
- 40 МИНУТ ЭГРХ СУДСАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИДЭГ

Цахим шууданд

ЕРӨНХИЙ ЦЭРГИЙН ОФИЦЕРУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб Ерөнхий цэргийн ассоциациас бэлтгэл, чөлөөнд байгаа бригадын генерал

Д.Энхбаатар, Г.Энхбаатар тэргүүтэй Ерөнхий цэргийн 60 орчим офицерыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэв. Энэ хүрээнд Сүхбаатар аймаг

сүндэрлэсэн генерал нэрэмжит цогцолборт хүндэтгэл үзүүлэн цэцэг өргөж, 300 ширхэг мод тариллаа.

хурандаа Ж.Ёндогийн "Соёмбо"

САЙН ҮЙЛСИЙН АЯНААР...

Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Улсын Их хурлын гишүүн Д.Батлутын санаачилгаар сайн үйлсийн аянд ангийн бие бүрэлдэхүүн нэгдлээ.

Тодруулбал, энэ сарын 3-14-ны өдрүүдэд Орхон аймгийн Баян-Өндөр сумын Уртын гол багт оршин суугч өрх толгойлсон 4 хүүхдийн ээж А.Жансалмаа 5*6 харьцаатай блокон байшинд бүрэн засвар, Баян-Өндөр сумын уртын голд оршин суугч өрх толгойлсон 8 хүүхдийн ээж Д.Ганчулуун 5 ханатай Монгол гэрийг засаж, шинэчлэх ажилд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллалаа.



"ТЭРБУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД

Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Монгол Улс тэрбум мод тарих, эх дэлхийгээ хайрлан хамгаалах, цөлжилтийн эсрэг зохион байгуулж буй үндэсний хөдөлгөөнд Зэвсэгт хүчний анги салбарууд идэвхтэй оролцож тэргүүлэх үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд Зэвсэгт хүчний 326 дугаар анги мөн адил нэгдэн анги байгууллагынхаа ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх бие бүрэлдэхүүнийг эрүүл орчинд ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Энэхүү ажлыг албаны дарга, экологич ахмад Д.Дагвасүрэн хариуцан ажиллаж байгаа бөгөөд ангийн



хэмжээнд одоогоор улиас 460, шар хуайс 150, улаан сухай 20, улаалзганын мод 10, чацарганын мод 20 суулган, ургуулах арчлан хамгаалах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Мөн түүнчлэн 5000 улиасны тайрдыг үрслүүлэн, хөрсийг нь боловсруулж суулгахаар бэлтгэж байна.

Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР



АМЖИЛТЫН БУУХИА ҮРГЭЛЖИЛСЭЭР...

Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Монгол Улсад олс таталтын холбоо үүсэж хөгжсөний 20 жилийн ойн арга хэмжээнд зохион байгуулагдсан Улсын аварга шалгаруулах олс таталтын тэмцээний гадаа талбайн элсэн дээрх төрөлд Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдаас бүрдсэн баг тамирчид амжилттай оролцож, мөнгөн медаль, мөнгөн шагналын эзэд боллоо.

Уг тэмцээнд хугацаат

цэргийн алба хаагчдаас бүрсэн баг тамирчид 2 сарын хугацаанд бэлтгэлээ ханган,

анх удаагаа оролцож, дэд байранд шалгарсан юм.

Ахмад Э.ГАНБАЯР



ГЭР БҮЛИЙН ӨДРӨӨР ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН АР ГЭРТ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Монгол цэрэг энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж эхэлсний 20 жилийн ойг Зэвсэгт хүчний 340 дүгээр ангиас Бүгд Найрамдах Өмнөд Судан улс дахь Нэгдсэн Үндэсний Байгууллагын энхийг дэмжих "UNMISS" ажиллагааны 11 дүгээр ээлжид үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын гэр бүлийн төлөөллийг олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан хүлээн авч

уулзлаа. Тус арга хэмжээ нь хилийн чанадад үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын гэр бүлийн тогтвортой харилцааг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор тэдний ар гэрийг ангийн байрлалд хүндэтгэн урьж нэгэн өдрийг хамтдаа инээд хөөрөөр дүүрэн өнгөрүүлээ.

Уг арга хэмжээнд 0-12 насны 16 хүүхэд болон эцэг, эхийн төлөөлөл оролцсон бөгөөд үйл ажиллагааны үеэр ангиас энхийг дэмжих ажиллагааны

талаар танилцуулга хийж, ангийн үлээвэр найрал хөгжимчдөөс урлагийн хэсэгчилсэн тоглолт үзүүлэн, гэр бүлүүдийн дунд хөгжөөнт тэмцээн зохион байгуулж, цэргийн гал тогооны бие бүрэлдэхүүн хүүхдүүдэд зориулан амтат бялуу, үзийн шүүсээр үйлчиллээ. Мөн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын илгээсэн цахим мэндчилгээг гэр бүлийнхэнд нь дамжуулж гэнэтийн бэлэг барьсан бол ангийн зүгээс гэр бүлүүдэд нь дурсгалын зүйл хадгалуулаа.

Д.УЯНГАА

УУЛЧИН ДАЙЧИД "ЕРӨНХИЙ ЦЭРГИЙН ӨДӨР"



цэргийн алба хаагчдын дунд Монгол Улсын цэргийн дүрмүүд, тактик, танин мэдэхүйн асуултын хүрээнд асуулт хариултын "Центавр" тэмцээн, хурд хүч тэсвэр хатуужил сорьсон "Буухиа" тэмцээнийг тус тус зохион явууллаа. Цэргийн алба хаагчдын цэргийн дүрэм, тактикийн мэдлэг, оюун ухаан шалгасан асуулт хариултын "Центавр" танин мэдэхүйн тэмцээнд 8 баг оролцож ахлах дэслэгч Э.Дүрвээ ахлагчтай

Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

Ангийн Ерөнхий мэргэжлийн офицеруудын санаачилгаар Орчин цагийн Мотобуудлагын цэрэг үүсэн байгуулагдсан 66 жилийн ойн өдрийг тохиолдуулан "Ерөнхий цэрэг"-ийн мэргэжлийн ангийн нийт бие бүрэлдэхүүнд сурталчиллаа.

Ангийн захирагч хурандаа Ц.Буянтогтох баярын хурлыг нээж Ерөнхий цэргийн мэргэжлийн офицер, ахлагч нартаа баяр хүргэж, ажил хөдөлмөрт нь амжилт хүссэн бол үргэлжлүүлээд захирагчийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга дэд хурандаа С.Бат-Эрдэнэ Ерөнхий цэргийн мэргэжлийн түүхэн хөгжлийн талаар танилцуулга хийв.

Мөн энэ үеэр Ерөнхий



цэргийн офицеруудаас ангиас боловсруулагдан гарч буй баримт бичгийн стандарт, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор штабын алба, салбаруудад 2 ширхэг принтер, 100 ширхэг баримт бичгийн хавтсыг бэлэг болгон өгч, баярын мэнд хүргэж, албанд амжилт хүслээ.


Тус арга хэмжээний хүрээнд баярын хурал,

баг тамирчид 84 оноогоор тэргүүн байр эзлэв. "Буухиа" тэмцээнд 9 баг өрсөлдсөнөөс ахмад Ц.Чирдагтовуучий захирагчтай уулын нэгдүгээр ротын баг тамирчид тэргүүн байр, ахмад М.Чинзориг захирагчтай уулын хүнд ротын баг тамирчид дэд байр, ахлагч Б.Бат-Эрдэнэ ахлагчтай баг тамирчид гуравдугаар байрт тус тус шалгарлаа.




Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ



ЦАХИМ ХУУДАС



* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)